



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 0/487

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Дотоод аудитын
албаны эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,612,000.0 /нэг сая зургаан зуун арван хоёр мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн Дотоод аудитын алба /Д.Мягмарсүрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад дурдсан 5 нэр төрлийн 1,134,000.0 /нэг сая нэг зуун гучин дөрвөн мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 2 нэр төрлийн 478,000.0 /дөрвөн зуун далан найман мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн Дотоод аудитын алба /Д.Мягмарсүрэн/-д үүрэг болгосугай.


3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 11 сарын
25 өдрийн 01/17 дүгээр тушаалын хавсралт



ДАНСНААС ХАСАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Дотоод аудитын алба

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ комиссын хурлын шийдвэр
Машин тоног төхөөрөмж										
1	Гадаа камер	5	ш	1	120,000	120,000	120,000	0	эвдэрсэн	актлах
2	Дотоод камер	5	ш	2	110,000	220,000	220,000	0	эвдэрсэн	актлах
3	Хатуу диск	5	ш	1	80,000	80,000	80,000	0	эвдэрсэн	актлах
4	4 сувгийн бичигч	5	ш	1	120,000	120,000	120,000	0	эвдэрсэн	актлах
5	Зургийн аппарат /Samsung/	5	ш	1	280,000	280,000	247,333	32,667	эвдэрсэн	татах
Тоног төхөөрөмжийн дүн						820,000	787,333	32,667		
Тавилга эд хогшил										
6	Сандал хар	6	ш	1	198,000	198,000	157,740	40,260	эвдэрсэн	татах
Тавилга эд хогшлын дүн						198,000	157,740	40,260		
Биет бус хөрөнгө										
7	Вэб сайт	6	ш	1	594,000	594,000	594,000	0	эвдэрсэн	актлах
Биет бус хөрөнгийн дүн						594,000	594,000	0		
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						1,612,000	1,539,073.46	72926.54		
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө						478,000				
Актлах хөрөнгө						1,134,000	0	0		